

ДАРХАН-УУЛ АЙМАГ



ДАРХАН СУМЫН 5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН “ТУРШИЛТЫН ТАЛБАЙ”-Н ТӨСӨЛ

2026 ОН

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ТЭРГҮҮНИЙ 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ТУРШИЛТЫН ТАЛБАЙН ТӨСӨЛ**

1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн V цэцэрлэг

Хаяг: Дархан сум 13 дугаар баг

Утас: 99028569

Эрхлэгч: О.Нандин-Эрдэнэ

И-мэйл: sub5.da@moes.edu.mn

2. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

- Сургалт, үйл ажиллагаа болон ногоо боловсруулах туршилтын талбай байгуулах төсөл

Төслийн төрөл:

- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 2-5 настай хүүхдийн сургалтын орчин сайжруулах замаар амьдрах ухааны чадавхыг дэмжих төсөл

Санхүүжилтын хэмжээ: 12.199.750 төгрөг

- Хэрэгжүүлэх хугацаа: 2026 оны 5 дугаар сард

3. ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

- Дархан сумын ИНХТөлөөлөгч Г.Батбилэг

4. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р цэцэрлэг нь 1970 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ашиглалтанд орсон. 280 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас одоогоор 425 хүүхэд, 44 багш ажиллагсдын бүрэлдэхүүнтэй, 2-5 хүртэлх насны хүүхдэд Сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлж байна. Тус цэцэрлэгт Дархан сумын 13-р багийн 290 хүүхэд бусад багийн 135 хүүхэд суралцаж байна.

Хүүхдийн сурч хөгжих ая таатай орчин нөхцлийг бүрдүүлэн багш ажилчдын өөрсдийн нөөц бололцоо болон эцэг эх, асран хамгаалагчдын хандив тусламжаар цэцэрлэгийн барилга байгууламжийг тохижуулан, сэргээн засварлах ажлыг жил бүр тогтмол хийж гүйцэтгэж ирсэн. Мөн бид өөрсдийн нөөц боломжид тохируулан цэцэрлэгийн арын хоосон талбайг тохижуулж, хүүхдийн тоглох эрүүл таатай орчныг бүрдүүлэхэд цэцэрлэгийн нийт эцэг эх, асран хамгаалагч нарын сайн дурын хөрөнгө оруулалтаар тохижилт үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшиж буй хүүхэд бүрт байгаль орчин танин мэдэх, эрүүл хооллолтын ойлголт авах, хөдөлмөрийн дадал төлөвших, туршилт судалгааны сонирхол хөгжих шаардлага өндөр байдаг. Иймд бид цаашид хүүхдийн оролцоонд суурилсан сургалтын орчныг сайжруулах, эрүүл хооллолт, байгаль орчин хамгаалах, хөдөлмөрийн зөв дадал төлөвшүүлэх зорилгоор сургалтын орчныг баяжуулах практик сургалт үйл ажиллагаа зохион байгуулах туршилтын талбай байгуулах нэн шаардлагатай байна.

5. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Цэцэрлэгийн гадна талбайд орчин үеийн чанар стандартад нийцсэн хүүхдийн аюулгүй эрүүл орчныг хангасан амьдрах ухааны сургалт болон хүнсний ногоо боловсруулах туршилтын нэгдсэн орчин бүрдүүлэхэд оршино.

6. ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- Хүүхэд хамгааллын орчинд хүүхдийн эрүүл аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх
- Цэцэрлэгийн гадна талбайд сургалтын туршилтын талбай байгуулах
- Сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшиж буй хүүхдүүдэд ногоо тарих, арчлах сургалт зохион байгуулах
- Анхан шатны ногоо боловсруулах сургалт явуулах
- Сургалтын хэрэглэгдэх орчныг нэмэгдүүлэх

7. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Талбай сонгох, зураг төсөл боловсруулах
- Ногооны мандал байгуулах
- Усалгааны систем суурилуулах
- Сургалтын орчин тохижуулах
- Ногоо боловсруулах сургалтын булан байгуулах
- Сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах

8. СУРГАЛТ АШИГЛАЛТ

- Ногоо тарих сургалт
- Ургамал арчлах сургалт
- Ногоо боловсруулах туршилт
- Эрүүл хооллолтын сургалт

9. ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 13 дугаар багт байрлах 5 дугаар цэцэрлэгийн 44 албан хаагч, тус цэцэрлэгт суралцан сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж буй 425 хүүхэд болон шууд бусаар шим хүртэгч эцэг эх, асран хамгаалагчид, багш ажилчид болно.

10. ТӨСЛИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

- Хүүхдийн сурч хөгжих орчин нөхцлийг сайжруулахад чиглэсэн шаардлага хангасан чанар стандартын туршилтын талбайтай болсон байна

- Хүүхдийг амьдрах ухааны чадамжид сургах, бие даах чадварыг нэмэгдүүлэх замаар бүтээлч эх оронч сэтгэлгээг байгаль нийгмийн туршилтаар хөгжүүлсэн байна.

11. САНХҮҮГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨСӨВ

№	Бараа бүтээгдэхүүний нэр төрөл	Эзлэх талбай хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Дүн (₮)
3	Моносны төгөл Монос мод 2 настай 0,8м өндөр мод	8*8 м ²	16	9.500	152.000
4	Чацарганы төгөл Чацарганы мод 2 настай 1м өндөр	8*8 м ²	16	5.500	88.000
5	Голт бор мод 3 настай 0.8 м өндөр	8*4 м ²	16	6.500	104.000
6	Үхрийн нүдний мод 3 настай 1,2м өндөр	6*8 м ²	16	8.500	136.000
7	Нохойн хошуу 2 насны 80 см өндөр	6*8 м ²	16	6.500	104.000
8	Хөх далан хальс 4 настай 1,2м өндөр бортоготой хөрстэй мод	6*9 м ²	18	35.000	630.000
9	Гацуур мод 4 настай 80 см өндөр	20		400.000	8.000.000
10	Зүлэгжүүлэлт олон наст зүлэгний үр /Экстра ургамал төв/	800мкв	35кг	42.450	1.485.750
11	Цэцгийн үрсэлгээ	3 төрөл	200	2,500	1.500.000
Нийт дүн:		12.199.750			

12. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

- Цаг агаарын нөхцлөөс шалтгаалах эрсдэл
- Ургамлын ургалт муудах эрсдэл
- Хүлэмж болон бусад талбайн ашиглалтын үеийн элэгдэл


13. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

- Улирал тутам дотоод хяналтын шалгалт хийх
- Цэцэрлэгийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн оролцооны үнэлгээ хийх
- Жилийн үр дүнгийн тайлан гаргах

14. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЛТИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Жил бүр улирлын ногоо тариалах /өөрсдийн нөөц боломжид тохирсон/
- Эцэг эх, асран хамгаалагч болон багш, ажилчид хамтран арчлах
- Сургалтын хөтөлбөрт тогтмол ашиглах

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН
ЭРХЛЭГЧ
О.НАНДИН-ЭРДЭНЭ



Цэцэрлэгийн туршилтын талбайн бодит төсөөлөл зураг

